



МАНДАЛ
ДААТГАЛ

**ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРАЛ
2025**

2025.04.26 | 14:00 цаг

АГУУЛГА

> Хурлын зар	3
> Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар, хугацаа	4
> Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн	4
> Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын тогтоол	5
> Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүн	7
> Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг	8
> Компанийн 2024 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан танилцуулах	9
> Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах	13
> Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах	19
> Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэр танилцуулах	21
> Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлуулах	22
> Тогтоолын төсөл	23
> Саналын хуудас	25
> Итгэмжлэлийн загвар	28

ХУРЛЫН ЗАР

“Мандал Даатгал” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Ээлжит хурал” гэх)-ыг 2025 оны 04 сарын 26-ны өдрийн 14 цаг 00 минутаас “Мандал Даатгал” ХК-ийн албан ёсны фэйсбүүк www.facebook.com/mandaldaatgal хаягаар дамжуулан цахимаар хуралдах тул та бүхэн хуралдаа идэвхтэй оролцоорой.

Хувьцаа эзэмшигчдийн ирц, санал хураалт, асуултыг www.investmentexpo.mn сайтаар хүлээн авна.

Ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн, шийдвэрлэнэ. Үүнд:

1. Компанийн 2024 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;
2. Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлт танилцуулах;
3. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
4. Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэр танилцуулах;
5. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах;

Ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр нь 2025 оны 04 сарын 04-ний өдөр (цаашид “Бүртгэлийн өдөр” гэх) байна.

Бүртгэлийн өдрөөр тасалбар болгосон Хувьцаа эзэмшигчийн нэрсийн жагсаалтад орсон хувьцаа эзэмшигч нь Ээлжит хуралд өөрөө эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцох эрхтэй ба Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө – 24, Паркплэйс оффис, 3 давхар хаягаар болон Тооллогын комиссоор дамжуулан Ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд өгөх саналаа саналын хуудсаар урьдчилан өгөх боломжтой.

Хэрэв хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийг төлөөлөн хуралд оролцогч нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар, Гүйцэтгэх захирал биш бол хуулийн этгээдээс олгосон хүчин төгөлдөр итгэмжлэлийг заавал авчрах шаардлагатай. Саналын хуудсаар санал авах сүүлийн хугацаа 2025 оны 04 сарын 26-ны өдрийн 14 цаг 00 минут хүртэл байна.

Ээлжит хурлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн байранд болон хурал зохион байгуулах комиссын дараах хаягаар холбогдон авна уу.

№	Комиссын гишүүдийн нэрс	Утасны дугаар	Шуудангийн хаяг
1	Б.Энхтүвшин	7577-3000, 9903-4515	enkhtuvshin@mandal.mn
2	Г.Одгэрэл	9904-9653	Odgerel@mandal.mn

Ажиллах цагийн хуваарь: Ажлын өдрүүдэд 9⁰⁰–17⁰⁰ цагийн хооронд ажиллана.

Компанийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 24, Сөүл рестораны баруун талд Паркплэйс Оффис, 3 давхарт.

Имэйл: enkhtuvshin@mandal.mn

Утас: 7575-2000

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦВАЛ ЗОХИХ МЭДЭЭЛЭЛ, БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчид нь 2025 оны 03 сарын 17-ны өдрөөс эхлэн 2025 оны 04 сарын 26-ны өдрийг хүртэл ажлын өдрүүдийн 09:00 – 17:00 цагийн хооронд “Мандал Даатгал” ХК-ийн оффист болон өөрийн харилцаж буй брокер, дилерийн компаниуд дээр очиж дараах баримт бичгүүдтэй танилцах боломжтой. Үүнд:

1. Хурлын зар;
2. Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар, хугацаа;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн;
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын тогтоол;
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүн;
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг;
7. Компанийн 2024 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан;
8. Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлт;
9. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлт;
10. Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэр;
11. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны зардлын төсөв;
12. Тогтоолын төсөл;
13. Саналын хуудас;
14. Итгэмжлэлийн загвар.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Зохион байгуулах комиссын дарга: *Б.Энхтүвшин /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/*

Зохион байгуулах комиссын гишүүд: *Н.Хүслэн /Маркетингийн ахлах менежер/
Г.Одгэрэл /Комплаенсын менежер/*

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



МАНДАЛ
ДААТГАЛ

2025 оны 03 сарын 14 өдөр
Дугаар 25/004
Улаанбаатар хот

МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйл, 71 дүгээр зүйлийн 71.3 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам” болон, “Мандал Даатгал” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрэм (цаашид “Дүрэм” гэх)-ийн 8-р зүйлийн 8.13.3 болон 8.13.4 дэх хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 сарын 26-ны өдрийн 14 цаг 00 минутаас “Мандал Даатгал” ХК-ийн албан ёсны фэйсбүүк www.facebook.com/mandaldaatgal хаягаар дамжуулан цахимаар хуралдуулсугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ирц, санал хураалт, асуултыг www.investmentexpo.mn вэбсайтаар хэрэгжүүлсүгэй.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
 - Компанийн 2024 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;
 - Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
 - Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
 - Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэр танилцуулах;
 - Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 сарын 04-ний өдрөөр тасалбар болгон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр хийлгэсүгэй.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг энэхүү тогтоолын **Хавсралт №1**-ээр баталсугай. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2025 оны 03 сарын 29-ний өдөр болон 2025 оны 04 сарын 11-ний өдрүүдэд өдөр тутмын сонинд, Компанийн www.mandal.mn вэбсайт болон Монголын хөрөнгийн биржийн www.mse.mn цахим хуудсаар 2025 оны 03 сарын 19-ний өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой Хувьцаа эзэмшигчдийн танилцвал зохих мэдээлэл, баримт бичгийн жагсаалтыг **Хавсралт №2**-оор баталсугай.

МАНДАЛ ДААТГАЛ ХК | Регистрийн дугаар: 5473489
Хаяг: Паркплэйс Оффис, Чингисийн өргөн чөлөө-24, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Улаанбаатар хот 14241, Монгол улс
Шуудангийн хаяг: Ш/х-2772/2292, Улаанбаатар 15160

☎ (976) 7575 2000
✉ info@mandal.mn
🌐 www.mandal.mn

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



МАНДАЛ
ДААТГАЛ

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 25/004

Улаанбаатар хот

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудлаар өгөх саналыг саналын хуудсаар авах бөгөөд саналын хуудасны агуулга болон загварыг **Хавсралт №3**-аар баталсугай. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн оролцоогүй боловч саналын хуудсаар дамжуулан урьдчилан саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хуралд оролцсон гэж үзэх бөгөөд уг саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа нь 2025 оны 04 сарын 26-ны өдрийн 14 цаг 00 минут хүртэл байна.
8. Энэхүү тогтоол батлагдан гарсантай холбогдуулан 2025 оны 03 сарын 17-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл, энэхүү тогтоолын Хавсралт №1 болон Хавсралт №2 дахь мэдээлэл болон Компанийн тухай хуулийн 80.11-г заасан мэдээллийн хамт хүргүүлсүгэй.
9. Энэхүү тогтоол батлагдан гарсантай холбогдуулан Хавсралт №2-оор баталсан мэдээлэл, баримт бичгийн төслийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр 2025 оны 03 сарын 22-ны өдөр хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компаниудад хүргүүлсүгэй.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Өлзийбаяр овогтой Ганзоригийг томилсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар батлах тогтоолын төслийг **Хавсралт №4**-өөр баталсугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг **Хавсралт №5**-аар баталсугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох толоологчийн итгэмжлэлийн загварыг **Хавсралт №6**-аар баталсугай.
14. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох мэдээлэл, баримт бичгийг хүргүүлэх, бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга Балдан овогтой Энхтүвшинд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ө. ГАНЗОРИГ

МАНДАЛ ДААТГАЛ ХК | Регистрийн дугаар: 5473489
Хаяг: Паркплэйс Оффис, Чингисийн өргөн чөлөө-24, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Улаанбаатар хот 14241, Монгол улс
Шуудангийн хаяг: Ш/х-2772/2292 Улаанбаатар 15160

☎ (976) 7575 2000

✉ info@mandal.mn

🌐 www.mandal.mn

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН



МАНДАЛ
ДААТГАЛ

2025 оны 03 сарын 14 өдөр
Дугаар 25/005
Улаанбаатар хот

МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Тооллогын комисс томилох тухай

“Мандал Даатгал” ХК-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулахтай холбогдон Тооллогын комиссыг томилох тухай асуудлыг хэлэлцэн, Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.13.4 дэх заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Мандал Даатгал” ХК-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Комиссын дарга: М.Сэнгэдорж (Эрсдэл, актуар хариуцсан ахлах менежер)
Гишүүн: Б.Оюунчимэг (Ахлах дата аналит)

2. Тооллогын комисс (М.Сэнгэдорж)-д дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай. Үүнд:

- Хурлын ирцийг бүртгэж хурлын даргад мэдээлэх;
- Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр саналын эрхтэй байх хувьцааны тоо, төрлийг тодорхойлох;
- Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах аливаа асуултад тайлбар огох;
- Санал өгөх журмыг тайлбарлах, хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хангах;
- Саналын хуудсыг тоолж, саналын хуудсыг хүлээн авах бөгөөд санал хураалтын дүнгийн тухай тэмдэглэл хөтлөх;
- Саналын дүнг нэгтгэн, санал хураалтын дүнгийн тухай Тооллогын комиссын шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах;
- Саналын хуудсыг компанийн архивд хадгалуулахаар шилжүүлэх.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ө. ГАНЗОРИГ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

Хугацаа	Хөтөлбөр	Хариуцагч
14:00 - 14:10	Хурлын ирц бүртгэх	Тооллогын комисс
14:10 - 14:15	Хурлын ирцийг мэдээлэх	Тооллогын комисс
14:15 - 14:20	Хурлын дэгийг танилцуулна	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
14:20 - 14:25	Хурлын дарга хурлыг нээж үг хэлнэ	Хурлын дарга – Ө.Ганзориг
14:25 - 14:40	Компанийн 2024 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан	Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Энхтүвшин
14:40 - 14:55	Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах	Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Энхтүвшин
14:55 - 15:05	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах	Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Энхтүвшин
15:05 - 15:10	Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэр	Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Энхтүвшин
15:10 - 15:15	Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлуулах	Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Энхтүвшин
15:15 - 15:35	Асуулт хариулт	Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Энхтүвшин
15:35 - 15:50	Санал хураалт	
15:50 - 16:05	Хурлын завсарлага, санал тоолох	Тооллогын комисс
16:05 - 16:10	Санал хураалтын дүнг танилцуулах	Тооллогын комисс
16:10 - 16:15	Хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулах	Тооллогын комисс
16:15 - 16:25	Хурлын дарга хурлыг хааж үг хэлнэ	Хурлын дарга – Ө.Ганзориг

МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2024 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

“Мандал Даатгал” ХК нь 2024 онд нийгмийн хариуцлагын хүрээнд “50 хүний амь аврах төсөл”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн бөгөөд төслийн хүрээнд дараах 2 ажлыг амжилттай хийж гүйцэтгээд байна. Эхний хийгдсэн ажил нь Улсын Гуравдугаар Төв эмнэлэгтэй хамтран, тус эмнэлэгт 50 тун алтеплазагийн хөрөнгө оруулалт хийсэн. Алтеплаза нь хурц шигдээс, харвалтын үед анхны шинж тэмдэг илэрснээс хойш алтан цаг буюу 2-4 цагийн дотор хийгдэх өндөр түвшний эмчилгээ юм. Шигдээс болсноос хойш хугацаа алдалгүй эмнэлгийн тусламж авч, протокол, удирдамжийн дагуу уг эмчилгээг хийхэд амь нас 100% аврагдаж, харвалтаас үүдэх хөдөлмөрийн чадвар алдалт, саа саажилт багасна. Хэдий хүний амь насыг богино хугацаанд аврах шидтэй тун ч гэлээ, нэг алтеплаза тунгийн үнэ өртөг нь өндөр учраас улсын хэмжээнд хүртээмж, нөөц хангалтгүй байдаг. Иймд “Мандал Даатгал” ХК-иас хүртээмжийг нь нэмэх, нэн яаралтай тулгамдсан үед хүний амь аврах боломжтой энэхүү эмээс 50 тунг захиалан Улсын Гуравдугаар Төв эмнэлэгт хүлээлгэн өгсөн. 2025 оны 02 сарын байдлаар 38 хүнд бүлэн хайлуулах эмчилгээ хийн амь насыг нь авраад байгаа юм.

Уг төслийн хүрээнд хийгдсэн дараагийн ажил бол “Нийслэлийн Онцгой Байдлын Ерөнхий Газар”-тай хамтран үер усны ослыг бууруулах зорилгоор 2022 онд Туул голын эрэг дагуух хамгийн их хүн цуглардаг хоёр байршлыг сонгон үер усны аюулыг мэдээлэх 2 цамхгийг байгуулсан ба 2023 онд нэмэлтээр 3 байршилд цамхаг байгуулж, тогтвортой үйл ажиллагааг ханган ажилласаар байна. Тус таван цамхагт 200 метрийн радиуст татаж хардаг хяналтын камерыг байршуулж, тухайн цамхагас гол дагуух иргэдэд анхааруулж, сэрэмжлүүлэх мэдээллийг дуут дохио ашиглан хүргэж ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн. Улаанбаатар хотын хувьд Туул голыг дагасан үер усны эрсдэлтэй бүсэд оршдог тул Нийслэлийн ОБЕГ-аас “завьт эргүүл” ажиллуулах, “Анхаарахад л болно” нөлөөллийн аяныг тус цамхагуудыг ажиллуулах ажилтай хамтатган хийснээр өнгөрсөн жилүүдэд үер, усны ослоос үүдэн амь эрсдэх тохиолдол 3.5 дахин буурч, цамхаг байршсан цэгт ослын тохиолдол бүртгээгдээгүй зэрэг үр дүн гарсан байна. Энэхүү цамхаг нь Олон улсын жишигт нийцсэн иргэдийн аюулгүй байдлыг хангахад чиглэж буйгаараа онцлог.

Үүний зэрэгцээ “Мандал Даатгал” ХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд дараах төслүүдийг хэрэгжүүлж байна:

- **Мандал Эрсдэлийн Сургууль** – 2021 оноос хэрэгжүүлж эхэлсэн уг төсөл нь 4-12 насны хүүхдүүдэд эрсдэлийн боловсрол олгоход чиглэсэн бөгөөд өдгөө 25,000 гаруй хүүхэд багачуудыг онлайн хичээлдээ хамруулаад байна. Монгол улсад жил бүр 40,000 хүүхэд урьдчилан сэргийлэх боломжтой шалтгааны улмаас эрүүл мэнд, амь насаараа хохирдог харамсалтай тоон мэдээлэл байдаг. Уг эрсдэлийг бид бууруулахын тулд өөрсдийн хувь нэмрийг оруулж 4-12 насны хүүхдүүдийн дунд түгээмэл тохиолдох эрсдэлүүдийн талаарх 2 бүлэг 18 видео хичээлийг тэдний хөгжлийн онцлогт суурилан бэлтгээд байна.
- **eDoctor** – Монголын хамгийн анхны эрүүл мэндийн цогц платформ юм. Улс орны хувьд ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгож хэрхэн өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зэрэг мэдлэгийг олгох нь нэн чухал асуудал байдаг. Уг хэрэгцээ шаардлагад үндэслэн бид бүх насныханд зориулсан эрүүл мэндийн боловсрол олгох цогц платформыг нэвтрүүлсэн билээ. Бид өдгөө 1.5 сая гаруй тогтмол уншигчтай болсон бөгөөд мэргэжлийн эмч нарын бэлтгэсэн 250 гаруй өвчний дэлгэрэнгүй мэдээлэл, 100 гаруй зөвлөмж нийтлэл, шинж тэмдэг дээр суурилсан өвчний асуумж ба зөвлөмж, эрүүл мэндийн тооцоолуур, эмнэлэг хайх зэрэг олон зүйлийг нэг дор багтаасан өргөн мэдээллийн сантай болоод буй.
- **Ажлын байртай, тэтгэлэгтэй элсэлт** – “Мандал Санхүүгийн Нэгдэл”-ийн охин компаниуд нь Санхүү Эдийн Засгийн Их Сургуультай хамтран “Санхүү&Банк”-ны бакалаврын зэрэг олгох

хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Уг хөтөлбөрийн хүрээнд нийт 14 оюутныг ажлын байраар хангахын зэрэгцээ, их сургуулийн сургалтын төлбөрийг шийдвэрлэлээ. Ингэснээр 3 жилийн хугацаанд бакалаврын зэрэг эзэмших бөгөөд онолын ба практик мэдлэгийг эзэмшиж, топ мэргэжилтэн болж төлөвших боломжийг бүрдүүлж байгаа юм.


“Мандал Даатгал” ХК нь жил бүр нийгэм, эдийн засагт тулгарч буй эрсдэлүүдийг шийдэх арга замыг эрэлхийлж, менежментийн арга туршлагаудаа хуваалцах зорилгоор Монголын ТОП бизнес эрхлэгчдэд зориулан “Next Leaders”, “Management Forum”, “Эрсдэлийн форум” зэрэг арга хэмжээг зохион байгуулдаг. Тус арга хэмжээнүүд нь бизнес эрхлэгчдэд хамтын ажиллагаагаа хөгжүүлэх, бизнесийн хүрээлэл болон борлуулалтаа тэлэх боломжийг олгодог гэдгээрээ онцлог. Монгол улсыг иргэдийнхээ өмнө сайн дураар өөрийнхөө бизнесийн үйл ажиллагаанаас давсан хариуцлага хүлээж чаддаг, хүнлэг том амбицтай компаниуд нэгдэн хөгжүүлж чадна гэдэгт бид итгэлтэй байдаг.

1. ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА


2024 оны 4-р улирлын байдлаар Нийт хураамжийн орлого 145.2 тэрбум төгрөг буюу 32.2%-иар өсөж, нийт зах зээлийн 29%-ийг эзэлж байгаа бөгөөд компанийн борлуулалтын төлөвлөгөө 120%-ийн биелэлттэй байна.

Цэвэр хураамжийн орлого сүүлийн 5 жилийн дунджаар 26% өссөн байна.

Нийт хураамжийн орлого, тэрбум төгрөг




Цэвэр хураамжийн орлого, тэрбум төгрөг



Нийт хураамжийн орлогын 50.2%-ийг Хөрөнгийн даатгал эзэлж байгаа нь өмнөх оноос 55%-иар өсөж, 72.9 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Хураамжийн орлогын бүтэц, бүтээгдэхүүнээр




Хөрөнгийн даатгал	50.2%
Машины даатгал	14.4%
Эрүүл мэнд	11.4%
Хариуцлагын даатгал	9.5%
Агаарын хөлгийн даатгал	8.8%
Бусад	5.7%


2024 онд 17,453 харилцагчдад 17.4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь өмнөх оноос 17.4%-иар өссөн бөгөөд нийт зах зээлийн 11%-ийг эзэлснээр салбартаа нөхөн төлбөр олголтоор 4 дүгээр байрт жагсаж байна. Мөн нийт нөхөн төлбөрийн тохиолдлын 94%-ийг шийдвэрлэсэн бөгөөд хохирлын харьцаа 45.8% болсон нь өмнөх оноос 4.8%-иар буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Нийт нөхөн төлбөрийн 40.1%-ийг Эрүүл мэндийн даатгалаар олгосон байна


Нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо



Нийт нөхөн төлбөрийн дүн, тэрбум төгрөг



Нөхөн төлбөрийн бүтэц, бүтээгдэхүүнээр



Эрүүл мэндийн даатгал	40.1%
Машины даатгал	38.3%
АЖД	8.8%
Хөрөнгө	5.9%
Бусад	6.9%


2. САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2024 онд хөрөнгө оруулалтын дүн 68.3тэрбум төгрөгт хүрснээр хөрөнгө оруулалтын орлого өмнөх оноос 17%-иар, хөрөнгө оруулалтын өгөөж 12%-иар өссөн байна.


Даатгалын үйл ажиллагааны орлого өмнөх оноос 196%-иар өсөж, 717сая төгрөгт хүрсэн нь Цэвэр ашиг 37%-иар өсөхөд нөлөөлсөн байна.

сая төгрөг	2023Q4	2024Q4	YoY
Даатгалын үйл ажиллагааны ашиг (Тө)	(744)	717	196%
Хөрөнгө оруулалтын ашиг (Тө)	7,057	8,272	17%
Цэвэр ашиг	6,090	8,332	37%
Өөрийн хөрөнгийн өгөөж	18.2%	23.0%	26%
Хөрөнгө оруулалтын өгөөж	16.1%	18.0%	12%
Төлбөрийн чадварын түвшин			
Хохирлын харьцаа	48.1%	45.8%	-5%
Зардлын харьцаа	58.0%	51.4%	-11%
Нийлмэл харьцаа	106.1%	97.2%	-8%
Нийт хөрөнгө	97,437	122,607	26%
Хөрөнгө оруулалтын дүн	49,943	68,339	37%


Нийт хөрөнгө, тэрбум төгрөг




Хөрөнгө оруулалтын дүн, тэрбум төгрөг



Нийт хураамжийн орлого, тэрбум төгрөг



Цэвэр ашиг, тэрбум төгрөг



3. ХУВЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТ

2024 оны жилийн эцэст MNDL хувьцааны ханш 70.5 төгрөг байсан бөгөөд өмнөх жилийн эцэстэй харьцуулахад 0.2%-иар буурч, нэгж хувьцаанд ногдох ашиг 13.35 төгрөг байна.

2024 онд нийт 1.7 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна



ХАРААТ БУС АУДИТЫН ДҮГНЭЛТ



A member of
Nexia
International

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК

Эмбасси Уан Бюлдинг, 606 тоот, 6-р давхар,
Элчингийн гудамж, 1-р хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар, Монгол Улс
Утас: +976 7700 1500
Веб хаяг: www.nexia.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

МАНДАЛ ДААТГАЛ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Аудиторын дүгнэлт

Бид Мандал Даатгал ХК (цаашид "Компани" гэх)–ийн 2024 оны 12 дугаар сарын 31–ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31–ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ")-өөс гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд ("СТОУС")–ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт ("АОУС")–уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн "Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага" хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан "Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм"–ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС–ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Компанийн удирдлага нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч "АОУС"–ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

ХАРААТ БУС АУДИТЫН ДҮГНЭЛТ



ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг (үргэлжлэл)

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлттэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)—ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг Компанийн удирдлагад мэдэгддэг.

Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор бус, Монгол Улсын "Компанийн тухай хууль"—ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогчид:



Улаанбаатар хот, Монгол улс
Огноо: 2025 оны 2 дугаар сарын 25

У.НАРАНДЭЛГЭР
Аудитор

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

МАНДАЛ ДААТГАЛ ХК

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ
САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

(Мянган төгрөгөөр)	2024.12.31	2023.12.31
ХӨРӨНГӨ		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,371,402	14,172,386
Санхүүгийн хөрөнгө	67,697,766	36,389,403
Хорогдуулсан өртгөөр бүртгэх	60,024,634	28,804,237
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх	3,373,254	2,989,600
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх	4,299,878	4,595,566
Даатгалын гэрээний хөрөнгө	2,978,029	4,733,085
Давхар даатгалын гэрээний хөрөнгө	3,646,721	1,196,720
Авлага	532,508	690,685
Урьдчилж төлсөн төлбөр, тооцоо ба бусад хөрөнгө	351,913	406,864
Бараа материал	23,737	41,772
Борлуулалтын зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	2,776,701	600,438
Үндсэн хөрөнгө	1,031,407	1,154,995
Ашиглах эрхтэй хөрөнгө	399,957	1,005,304
Биет бус хөрөнгө	105,226	173,445
Нийт хөрөнгө	<u>80,915,367</u>	<u>60,565,097</u>
ӨР ТӨЛБӨР		
Даатгалын гэрээний өр төлбөр	30,299,657	20,531,548
Давхар даатгалын гэрээний өр төлбөр	3,782,391	1,368,849
Дансны ба бусад өр төлбөр	1,832,650	1,383,240
Орлогын албан татварын өр төлбөр	91,718	281,692
Хойшлогдсон татварын өр төлбөр	156,041	156,041
Түрээсийн өр төлбөр	375,927	941,439
Нийт өр төлбөр	<u>36,538,384</u>	<u>24,662,809</u>
ЭЗДИЙН ӨМЧ		
